

Смит Дение

Европын социологийн холбооны дэд ерөнхийлөгч,  
"Current Sociology" сэтгүүлийн ерөнхий эрхлэгч,  
Их Британы Лотборогийн Их Сургуулийн профессор

(Орч) Х.Гүндсамбуу<sup>60</sup>

Социологийн ухааны доктор (PhD)

## ДАЯАРШЛЫН ДУУДЛАГА: ДОРМЖЛОЛГҮЙГЭЭР ЭНХ ТАЙВАНД ХЭРХЭН ХҮРЭХ ВЭ?

**Abstract:** Nowadays, a terminology "globalization" is invading spheres like everyday, linguistics, economics, politics etc. This is a question of mutual existence of nations with mutual interests. It is also interesting to give answers to questions like how can we reach this, is it possible, what could be sociologist's answer to them. Hereby, we bring a translation about these questions.

**Key words:** Globalization, political will, policy, war, conflict, society, chauvinism, insult, urban poverty.

Даяаршлын үйл явц даян дэлхий бүхий л хүмүүсийг ойртоход хүргэж байна. Дэлхийн хамтын нийгэмлэг хөгжихийн хэрээр дэлхийн хүчтэй бөгөөд шударга удирдлага (governance) бүтээхийн зайлшгүй нь тов тодорхой болов. Тэр нь үндэсний улсуудын том хариуцлага дээр суурилж, зөвшилцлийн зарчимд үндэслэх ёстой. Миний бодлоор тийм засаглал үүсэн . . . ийн зайлшгүй нь:

- ✓ Ямар нэгэн орны Засаглал бусад улсад өөрийн хүсэл зоригоо тулгадаг явдал энэ зуунд ямар ч байдлаар боломжгүй нь илэрхий. Түүгээр ч үл барам АНУ эл зорилтыг тогтооход хангалттай хүчгүй.
- ✓ Тиймэрхүү Засаглал дэлхийн гуравдугаар дайны үр дүнд үүсэж чадах байх, мэдээж тэр нь дайны төгсгөлд ерөнхийдөө хэнд, хэнийгээ засаглахаар оршино.
- ✓ Тэр нь үндэсний засгийн газруудын зөвшилцлийн замаар, хүн төрөлхтний хэрэгцээг хангахуйц хамтын хөтөлбөрүүд, нэгдмэл бодлого хэрэгжүүлэх замаар үүсэж болох юм.

Дэлхийн гуравдугаар дайн болох нь бага магадлалтай болохоор ийм сэдлэг хамгийн боломжтой болно. Үндэсний улсууд болон засаглалын байгууллагууд өөрсдийн иргэдийг дорд хийлгэхгүй байдлыг хангах нь дэлхийн удирдлагын амин чухал зорилгын нэг мөн. Хэрэгжүүлэх бодлогын өөр нэгэн чухал зорилт нь өнгөрсөн түүхэнд Европын колоничлогчид, үндэстэн дамнасан корпорациуд, дэлхийн зарим улсуудын авчирсан үй түмэн ... үзэлт, асар их гарз хохирлыг үгүй хийх ёстой.

Хүчтэй, шударга даяаршлын бодлого зорилт хүнд хэцүү, гэхдээ гүйцэлдэхгүй зүйл ч бишээ. Бүр 1945 он гэхэд даяаршлын түвшний институт байгуулах давалгаа үүсчээ. Даяаршлын удирдлагын үлэмжхэн хэсэг аль хэдийнээ оршиж байна. 40-50 иад оны эцэст АНУ-ын шаргуу чармайлтаар бодитой агаад хүндтэй зарчмуудыг агуулсан НҮБ-ийн Хүний эрхийн тунхаглал гарснаар эдгээрийн зонхилох механизмууд бүрэлдсэн билээ. Хэрвээ улс төрийн хүсэл зориг байх зам бол дэлхийн удирдлагын манай систем бий болно ч, цаашдаа ч хөгжинө.

Иргэний нийгмийн түвшин дэх идэвхийлэлтэй улс төрийн хүсэл зоригийн төлөвшил холбоотой бөгөөд үндэсний удирдагчид ард түмний тэмүүллийг тооцох нь мэдээж. Эцсийн эцэст хүмүүс энх тайван, хөгжил цэцэглэлийг хүсч байгаа. Түүнчлэн тэд аюул занал, гар мухардлаас зайлахыг хүсч байна. Тиймээс тэд эдийн засагчид, синомик шинжлэн

<sup>60</sup> Энэхүү орчуулгыг Социологийн ухааны дотор агсан Х.Гүндсамбуу багш маань насан хутаг олохынхоо өмнөхөн "Социологи" сэтгүүлд зориулан хэвлүүлэхээр өгсөн юм. Гэвч тухайн үед сэтгүүлээ хэвлүүлж чадаагүйн улмаас олон жилийн дараа ийнхүү хэвлүүлж байна. Түүний хамгийн сүүлийн орчуулгын бүтээл байж болох энэхүү орчуулгыг та бүхэнд хүргэхдээ цэг таслал ч засалгүйгээр тэр хэвээр нь хэвлэж хүргэхээр шийдлээ. Хугацаа алдсан тул хүлцэл өчье. Ред.

магадлагчдын санал бодлыг сонсох болно. Хэрвээ бид бүхэн эдгээр асуудлыг улаан халз, тов тодорхой ярих юм бол социологчдын үг хэлийг хүмүүс анхаарах болно.

Тухайн нийгмийн доторх болоод тэдгээрийн хоорондын доромжлолын мөн чанарыг бид ихээхэн анхаарах ёстой. Дорд үзэлтээс үүдсэн ядуурал, мөргөлдөөн нь хүмүүсийн амьдралд наад зах нь эдийн засаг юмуу цаг уурын мөчлөг шиг нөлөөлдөг. Бид, социологчид сэтгэл зүйчид, түүхчид, бусад түншүүдтэйгээ зэрэгцэн нэгэн орны дотор болон үндэсний улсуудын хооронд сүйтгэл мөргөлдөөнүүдийн үүслийн судалгааг тэргүүлэх ёстой. Түүнчлэн Нильсон Манделын ерөнхийлөгчийн үеийн ӨАБНУ юмуу 1945 оны дараах Европод тохиосон шиг дорд үзэлтийн мөчлөгүүдийн үеэрх нөхцөл байдлуудыг (тэдгээрийн сургамжуудыг) үндэслэн, бүлгүүдийн хоорондын эрс тэрс зөрчлүүдийг бүр нам түвшинд хүртэл судлах учиртай.

Хэрвээ бидний судалгаанууд Европи, Ази, Африк, Америк тивийг хамруулан, бидний хоорондын . . . түмний яриа хөөрөөтэй нягт уялдах юм бол энэхүү ажил ихээхэн үр нөлөөтэй болно. Бидний яриа хөөрөө үндэстэн, угсаатан, соёл, шашин шүтлэг, тэрчлэн мэдлэгийн чиглэлүүдийн хүрээнээс гадуур яригдах ёстой. Нийгэм судлаачид болон «мэдлэгийн мэргэжилтнүүд» нь стратегийн бүлгүүд юм. Бид дайн дэлхийн иргэний нийгмийн хүрээнд идэвхтэй ажиллаж байж, дурьдсан сэдвүүдээр зохион байгуулагдаж, өөрсдийн үүргээ гаргуун биелүүлнэ.

Үндэсний улсууд нягт харилцан үйлчилдэг зөвхөн тийм нөхцөлд л манай дэлхий ертөнц ажиллагаагүй миний талбай болж хувирна. Хэрэв «үхлийн бөмбөгийн» устгахад чиглэсэн тийм л хамтын ажиллагаанд хүрч чадвал дэлхийн хүчтэй, шударга удирдлагын дулаан дор хаяад газрын дунд хүрлээ гэж итгэл төгс хэлж болно. Мөргөлдөөнүүдийг өөрчлөхүйц чухал бөгөөд үнэ хүндтэй хөтөлбөрүүд улс орнуудын их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд бий: Дорд үзэлтийн мөчлөгүүдийн өөрчлөлтийг судлах: мэдлэгийн мэргэжилтнүүдийн яриа хөөрөөг нэгтгэх, даяаршлын хүчтэй, шударга удирдлагын уур амьсгал бүрдүүлэхийн тулд дэлхийн царааны иргэний нийгэмд үйл ажиллагаа явуулах гэсэн гурван зүйлийг би санал болгож байна. Үүнийг хийхгүй бол, бидний ирээдүйд тун баргар. ... бол ойрх дорно руу хандая. Дорд үзэхүйн мөчлөг, хариу өшөө авалт нь Израйл, Палестин хоёрыг бахинд зуулгаж байгаа юм. Израйл Авишан Маргалибын «Журамт нийгэм» хэмээх нэрт гарсан бүтээлийн зохиогч гайхалтай биш л дээ. Хэрэв нийгэм нь өөрийн гишүүдээ ямар нэгэн байдлаар дорд үздэггүй бол тэр нийгэм журамт нийгэм (Би хөршүүдийнхээ аль нэгийг гэж нэммээр байна) мөн санаа нэвт шувт харагдана. Бүхий л нийгмийн төлөө эрх баригчдын олгодог ашиг тус, үйлчил ... тэнцүүхэн байх бөгөөд тэднийг захирагч хэн бугайд ч, иргэд юмуу Аливаа субъектын үүрэг нь «шударга» гэсэн Б.Мурын үзэлтэй дээрхийг харьцуулжгаая. Хэрэв үүнийг мартвал, мартамгайд төлөх үнэ асар өндөр, хүний алтан амьтай л тэнцэнэ. Хяналтын цэгийг албадлагагүйгээр өнгөрүүлж, хаашаа ч явж болохгүй. Та бүхэн танихгүй хүнд итгэхгүй, нэг л соёлгүй, бүдүүлэгдүү санагдаж, «бүслэгдсэн» мэт өөрт мэдрэгдэнэ.

Нөгөө талаас мөргөлдөөнд оролцогчид зохимжтой харилцан буулт хийдэггүй ч ойлгохын аргагүй. Хойд Ирланд, Энэтхэг-Лажисбаны гэх мэт олон мөргөлдөөн үүнтэй эгээ нэг. Нөгөө талаас яагаад мөргөлдөөнд татагдан орсныг бидний олонх нь ажиглагчийн үүднээс ханддаг, тийм л байх юм шиг үзэгддэг. Бидний эсэргүүцэл үйл явдалд шийдвэрлэгч нь байх болно. 9 сарын 11-ний үйл явдал юмуу дараа нь «алан хядагчтай дайтсаны» хувьд саатахыг хүсэхгүй байна. Баримт сэлт өчүүхэн байгаа, олон хүний эмгэнэлийн шалтгаан тодорхойгүй байхад эдгээр үйл явдлын талаар ихийг ярина гэдэг үнэхээр хэцүү. 9 сарын 11 нь үнэн хэрэгтээ хэлмэгдэгчдийн хувьд төдийгүй дор үзэлтийн үйлдлүүдэд итгэгчдийн олонхид ч, дорд үзэлтийн хариу ч өшөө авагчдын хувьд эмгэнэлт өдөр байсан юм. Мөргөлдөөнд оролцогч бүх тал өөрсдийгөө золиос болсон гэж үзэх л юм бол хариу цохилт өгөх эрхтэй.

Дорд үзэгдэгчдийн ба гайхагчдын өнөөгийн даяаршмал мөчлөг нь зөв, буруутнаас үл хамааран хэмжээлшгүй үнэтэй болно. Сүүлийн үеийн мэдээллийн технологотой хувьсгал нь харилцаа холбооны өндөр түвшинд суурилсан шинэ «мэдлэгийн эдийн засгийг» (knowledge economy) төрүүлсэн юм. Энэхүү шинэ «сүлжээний нийгмийн» тодорхойлогч шинж нь хэн нэгэнтэй дурын агшинд холбогдож, товчлуур дарангуутаа хэрэгцээт мэдээллээ авах боломжтой оршино гэж Мануэль Кастельс бичсэн юм. Компанийн хөгжлийн стратеги, зорилтуудыг шууд оролцоогүйгээр шинэчлэх чадавхтай хөдөлмөрийн хамт олны шинэлэг хэлбэрүүд боломжтой болчихсон юм. Тийм орчин туршилтад бэлэн байдлыг төрүүлж, шинэчлэлд итгүүлж байна. Агаарын харилцааны хөгжингүй дэд бүтэц нь янз бүрийн төвд

орших ажил хэргийн түншүүдийг биечлэн уулзах зуураа тулгамдсан асуудлыг шүүн хэлэлцэх бололцоо олгож байна. Энэ нь хүмүүсийг ойртуулж, хамтран ажиллахад хүргэж, шинэ шинэ үзэл бодлын урсгалыг үүсгэж байна.

Хэрэв «алан хядагчидтай хийх дайн» сунжирвал тэр нь мэдлэгийн эдийн засагт ч, сүлжээний нийгэмд хүндхэн дуншилт болно. Хүмүүс зорчин явахаа болино. Аюулгүй байдлынхаа тухай сэтгэл нь үзэл бодлыг чөдөрлөнө. Нийгэмд бухимдлын уур амьсгал ноёлж, хөдөлмөрийн бүтээмж буурна.

Зарим дайн бүр эсрэгээр нийгмийн хөдлөнг чанарыг урамшуулдаг. Тухайлбал дэлхийн хоёрдугаар дайн Британи болон ЗХУ-ын ард иргэдийг эх орныхоо тусын тулд хүчээ зангидахад хүргэсэн. Эх орноос нь алсад явагдаж буй дайн үндэсний эдийн засагт тун ашигтайгаар нөлөөлдөг. Гэвч «алан хядагчидтай хийх дайн» нь даяаршлын шинэ эдийн хөгжлийг зогсоочих магадлалтай. АНУ асар их сүйрэлд орохгүйн тулд дотоод зах зээлээ хамгаалж болох юм. Гэхдээ АНУ бол томоохон экспортлогч орон. 11 сая гаруй ажиллагчид (АНУ-ын худалдааны яамны, мэдээллээр ажиллах хүчний нэг нь) гадаад ертөнцөд бараа, үйлчилгээ гарган амьдарч байна.

### Дорд үзэхүйн таастууд. (3.4.5)

Дорд үзэхүйн талаарх Эвилен Линднерын (6) бүтээл сонирхолтой ч, дорд үзэхүйн онол боловсрох замдаа яваа тул зарим чухал зүйлсийг эшлэлд (7-13) авлаа. Юуны өмнө тэмдэглэхэд миний бодоход дорд үзэхүй нь ичихтэй адилхан юм. Зохих ёсоор «үүргээ биелүүлж чадаагүй» гээ мэдэхлээрээ гол төлөв ичдэг. Гэвч үүнийг дор үзээгүй бол бид, тухайлбал нислэгийн үед мэргэжлийн нисэгчийн засаглалыг сайн дураараа хүлээж зөвшөөрдөг. Дор үзэлт бол шал өөр, бид . . . шууд цохилт өгдөгөөрөө эсрэг юм. Тэр нь «таны гүйцэтгэж буй үүрэг өөрийх чинь биш. Тэр нь та нарын хувьд дэндүү сайн учир бид хураан авая» хэмээн танд ярьсан шиг юм. Газар хөмөрчих л танд мэдрэгддэгээрээ дорд үзэлт нь ёс зүйн хувьд устгадаг.

Дорд үзэлт ертөнц мэт л хуучин зүйл.

- ❖ Давын өмнө нийгмийн болон улс төрийн зиндаархал оршин байдаг нь түүнийг тулган хүлээлгэх буурийг ямагт бий болгодог. Би үүнийг байлдан дагуулагч-дорд үзэлт (conquest-humiliation) гэж нэрлэж байна. Феодалууд чөлөөт хүмүүсийг эрхшээлдээ оруулах үед, чөлөөт хүмүүс боолчлолын дөнгөнд орох үед ямагт тийм буурь олдоно. Нийгмийг өөртөө захируулагч харийн байлдан дагалдуулагчийн үед дорд үзэлтийн тийм нөхцөл байдал зуршмал бөгөөд түүнийг ноёрхогч шинэ анги л гүйцээдэг. Нутгийн ноёд, гүнхэгийн харъяатнуудыг дэлхийн эзэнт гүрэн болтол хувиргасан Европчуудын үед тийм байв.
- ❖ Бүрэлдэж байгаа бослогыг дарах цагт гүйцэд бус үнэ цэнтэй юм шиг санагдах цагт шинэ шинэ доромжлолыг ялагчид тулган хүлээлгэх үед үзэн ядалт ундардаг. Үүнийг өсөн нэмэгдэх дорд үзэлт гэж нэрлэж байна. Зиндаархлын шатнаас доош уруудахад доромжлол бас бууриа олдог. Үүнийг би эрх байдлаа алдахын дод үзэлт хэмээн нэрлэж байна. Түүнийг ХХ зуунд баруун Европынхон амссан бөгөөд Америк тэднийг эзэнт гүрэн байхаас нь татгалзуулсан юм. Тэд дэндүү доромжлогдсон билээ. Эр чадалтай байсан хэр нь түүнээс доогуур харш гэдгийг нь түймэрт шатахаас аварсан, дараа нь нөхцөл байдал өнгөрөн одохлоор таны зүтгэл хэрэггүй байсан гэж ярих мэт.
- ❖ Зиндаархлын шатны гишгүүрүүдээр уруудуулаад зогсохгүй, бүлэг давхраанаас зайлуулж, магадгүй амь насыг нь бүрэлгэх тэр үед бас доромжлол тааралдана. Тийм доромжлолыг шахан зайлуулах доромжлол гэж нэрлэж болно. Оросод нударганчуудыг, Европод еврей нарыг хүчирхийлэл хийгээд бүрэн эрхийг шилжүүлэх замаар шахан зайлуулсан билээ. (4.p.541-544)

Хүний эрхийн дэлхийн хувьсгал болсноор доромжлолын хэр зэргэмж өөрчлөгдсөн билээ. Түүний мэргэн санаа нь бүх хүн аминдаа нэр төрийн мөхлөгтэй, түүнийг хүндэтгэн үзэх ёстойд байгаа юм. Хүмүүс даруухан, нэр төртэй амьдрах эрх чөлөө, нөөц боломжтой байх ёстой. Хүний дээрх эрхүүдийг алга хийх нь тэдний хүний мөн чанарыг үгүйсгэж, эрдэнэт хүнийх нь төрлөөс гаргаж буй хэрэг юм.

Хүмүүсийн хооронд туйлын ба арилашгүй ялгаанууд бэлэн эзлэн, төрөлхийн ялгаанууд оршдгийг үгүйсгэх нь хүний хувьсгалын тэнгэрлэг үндэс болно. Бүхий л нийгмийн тусын тулд оршин тогтнож байдаг тийм тохиолдлуудаас бусад бүх зиндаархлыг тэр эрс няцаадаг. Тэр нь бас ямарваа засаглал «ухаалаг», «үнэмшилтэй» байхыг шаарддаг. Тулгалт, доромжлол,

гадуурхал байж байдаг. Хүний өрхийн хувьсгал нь хүмүүсийг доромжлолын бүхий л хэлбэрт мэдрэмтгий болгоно. Хүмүүсийн дотоод нэр төрийг хуваавал цагаатгал бүхий эсэргүүцэл үзүүлэх, доромжлолын золиос болохгүй байх хүчирхэг үзэл суртлыг төр өгнө. Хэрэв хүмүүс дотоод нэр төрөө хамгаалж байвал доромжлолыг өөрийн адилсалаа тусгаарлахуйц, далдлахуйц боломж бүрэлдэнэ. Хүмүүс доромжлолыг янз бүрээр хүлээн авдаг.

- ❖ Нэг хэсэг нь доромжилсныхоо төлөө хариуцлага хүлээх ёстой нийгэм, бүлэг, бие хүнд гомддог. Энэ нь идэвхгүй эсэргүүцэл боловч архаг үр дагавартай, идэвхжихэд бэлэн байдаг.
- ❖ Доромжлолын эсрэг зогсож, зэмлэн буруушаах нь нэлээд идэвхтэй хэлбэр юм. Үндсэндээ далд эсэргүүцлийн үйлдлүүд нууцлаг, тухайлбал ар хударгаар нь муулах, далдуур үймүүлдэг.
- ❖ Хариу доромжлол үзүүлэх үндсэн дээр өшөөгөө авдаг бүр ч идэвхтэй эсэргүүцэл бий.
- ❖ Эцэст нь хамгийн харгис ба эрс эсэргүүцэл үзүүлнэ

Доромжлуулагчдын зүгээс сэтгэлзүйн хоёр алхам хийгддэг бөгөөд нэг дэх нь: дотоод нэр төрөө, өөрийгөө хамгаалах дотогшоо чиглэсэн, хоёр дахь нь: доромжлолд хүргэсэн гүн гүнзгий үйл явц, бүтцийг бодитойгоор авч үзээд доромжлолын үйлдлийн хилийг давах гэсэн гадагшаа чиглэсэн алхам юм. Хэрвээ үүнд хүрч чадвал хүн доромжлолын гай түйтгэрээс мултарна. Тэр нь үзэн ядалтаас татгалзаж, доромжлол ба сөрөг доромжлолын мөчлөгийг тасдана. Тэр нь доромжлолын мөчлөг үүсэх шалтгаан болдог үйл явц, бүтцийг өөрчлөхөд хүргэнэ.

Гэвч хэлэх нь хийхээс хамаагүй хялбар. Доромжлолын мөчлөгт үндсэн оролцогчдын итгэл, бүх талуудын хамтын үйл ажиллагаа нь стратегийн шийдлийг шаардана. Стратеги үр ашигтай ажиллаж чадах эсэх нь:

- ❖ Доромжлолын эхэн биенд түүнд оролцогч талууд үр дагавруудыг нь тооцон үзээд, түүнээс зайлсхийх;
- ❖ Мөчлөг нэгэнт эхэлчихсэн үед, бүх оролцогч талууд түүнийг үргэлжлэлийн үнэ цэнэ хэлбэрэлтгүй өсөхийг угтан харах;
- ❖ Мөчлөгийг сунжруулсан тохиолдолд бүх оролцогч талууд бүр мөсөн сульдан доройтохыг мэдрэх зэрэг болно.

Анхны хамгийн тод жишээ бол ӨАБНУ-ын Нельсон Манделагийн ерөнхийлөгчийн засаглалын хоёр дахь үе юм. Арьсны үзэл төгсгөл болсныг тэр үеийнхэн бүгдээрээ мэдэж байлаа. Цагаан арьстны эсрэг өнгөт арьстны бослого гарна гэдгээс дагжин чичирч байв. Мандела ерөнхийлөгч боловч гай барцдаас татгалзаж, хамтран зүтгэгчдээ итгүүлсэн, цагаан арьстны тэргүүлэх эвлэрлийн хөтөлбөрүүдээр дамжуулан цагаан арьстнуудтай хоёр талын яриа хөөрөө тогтоосон билээ.

Гуравдахь нөхцөл байдлын жишээ 1950-иад оны хуучнаар Европын холбоонд эхлэв. Түүний язгуур үндэс нь Франц, Германы нягт хамтын ажиллагаа байв. 1860-1945 он хүртэл энэ хоёр улс доромжлол, басамжлалын мөчлөгүүдийн олзлогсод болсон билээ. Европын холбоо үүсэн байгуулагдсанаасаа хойш дөчин жилийн дараа л гайхалтай амжилтад хүрсэн гэж болно. Герман, Франц ойртоод зогсохгүй эзэн, харьяат явсан Англи, Ирланд эвлэрэв. Итали, Португал, Грек зэрэг бардам үндэстнүүдийн ачаар нэр төрөө алдалгүй буурай хөгжилтэй бүсүүд хөгжингүй бүсүүдээсээ хөгжлийн тусламж авах арга замыг нийтийн зах зээл олов. Европын холбоо Европын бүх иргэдэд ашигтай стандарт, дүрмүүдийг тогтоов. Горим дүрмээс ухрах, авилга авах явдал байсан нь мэдээж. Гэхдээ бид хяналтаас мултарч ч байв. Европарламент Еврокомиссын огцрох явдалд баттай хөндөлсөж, хүчтэй доромжлолоос өөрийн шүүмжлэл чухлыг нотлов.

Европын Холбооны амжилт нь үндэстэн хоорондын олон мянган идэвхтэй улс төрчид, дипломат ажилтнууд, шинжлэн магадлагчид, түшмэдүүдээс хамаарна. Энд загалмайлсан эцэг маягийн давамгайллагч оролцогчид байхгүй. Европын Холбоо бол ямар нэгэн дүрэмдэгчийн дээдсэрхэг хэрэгцээг мэдэрдэггүй. Энэ нь хамгийн олон түмний хөдөлгөөн. Гэхдээ . . . мэргэжилтнүүдийнх гэдэг нь эргэлзээгүй. Өөрөөр хэлбэл холбооны хөдөлгөөнд шинжлэн магадлагчид, технократууд, дипломатууд, судлаачид, Европын хөдөлгөөний мөн чанар нь хамтын ажиллагааг хэрэгжүүлэх арга замыг хайж, хамтран ажиллах тэмүүллийг төрүүлж, хүчирхийллийг чинхүү зайлуулахад оршино. Миний бодоход хамгийн сэтгэл татам зүйл бол Европын хөдөлгөөнд даяаршлын түвшинд гадаад бодлоготой болсон ба үүнийг даяаршмал

хамтын ажиллагаанд чиглэсэн бодлого хэмээн хэлж болно. Хамгийн их холбоорой. Ирээдүйн Европын зөвлөлийн гадаад хэргийн сайдууд Европын Холбооны дарга, засгийн газруудын тэргүүн нартайгаа хамтдаа хуралдаж байхыг санал болгосон юм. (2002 оны IX сарын 13-нд Гардиан сонинд өгсөн сурвалжлагыг үзнэ үү). Олон улсын харилцаанд доромжлолын өв залгамжлалыг гэтлэн давах хамгийн сайн арга бол нэр төрийг хугалахгүйгээр бүхнийг хамарсан "бид" гэж хэлэх адил . . . хүмүүсийг тойруулан нэгтгэх явдал мөн.

Энэхүү үйл явц Европод эхэлсэн. Европчууд, Хятадууд, Америкчуудын тулд хэн нэг нь дэлхийн иргэн юмуу бие хүн хэмээн үзэхүйц болгохын тулд дэлхийн түвшин дээр, . . . үйл явцыг эхлүүлэх цаг тулгарлаа. Би Европыг алдаршуулах гээгүй. Зүгээр л доромжлолгүй энх тайванд хүрэх, үндэсний улсуудын зэвсгийг хураах, дэлхийн удирдлагыг бэхжүүлэх мэтийн агуу зорилгод хүрэхэд ашиг тустай хэрэгсэл нь түүхэн тодорхой туршлага юм.

Гэвч, заасан замаар урагшлая гэвэл энэхүү зам дээр хоёр том бул хар чулуу байгааг тооцох ёстой. Нэг дэх нь АНУ-ын төлөв байдлын, хоёр дахь нь даяаршлын "Өмнөдийн" хотууд дахь ядуурлын асуудал юм. Энэ хоёр нь түгшүүрийн харанга дэлдэж байна. Ямар нэгэн «шийдлийг» санал болгох гээгүй. Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд бид бүхнээс оролцоо боломж олгохуйц аргуудыг санал болгож байна.

### АНУ дахь төлөв байдал

АНУ-д доромжлолын мөчлөгүүдэд хандах «Европын» логиктой эртнээс танил юм. Тэр нь хамтын ажиллагааны суурь болсон Маршаллын төлөвлөгөөгөөр дамжин Европын улсууд нягт хамтран ажиллахад чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. (З.ж 134-147). Одоо даяаршлын түвшинд тиймэрхүү юм яагаад ганц ч байхгүй байна вэ? Товчоор хэлэхэд Америкийнх өөртэй нь хав дараастай оршин байсан санал бодлыг туйлшруулсан. Хэрвээ Европ хүчирхийллийн тухай сэтгэлгээг үзэн яддаг бол Америк дэг журмыг зөрчих тухай сэтгэлгээг үзэн яддаг. Түүний иргэд, сайн тал руу татахад дэлхийн бусад ардаас ялгардаг сэтгэлгээтэй зууралдсан байдаг. Ертөнц бидний хойноос явж байна, хошуучлалаа алдахаас, хоцрохоосоо айж байна гэж л тэдэнд харагддаг.

Нэгдсэн Америк бол амжилтынхаа л золиос болсон. Америкийн «аж төрөх ёсны» үзэх санааг талархах нь бараг л дэлхийг нэлд нь нөмрөөд байв. Бид бүгдээрээ амьдралаа хөнгөвчлөхийн тулд ердийн элгэмсүү жижигхэн юмны тусламжтайгаар юу хүссэнээ авдаг, өөрийнхөө амьдралыг хянан зохицуулдаг, аз жаргалтай, ижил төгс «жирийн» хүмүүс буюу зар сурталчилгааны бамбайтай хүмүүсийн хажуугаар явахыг хүсэж байна. Энэхүү «Америк мөрөөдөл» нь бүх төвүүдийн тариачны уламжлалд үндэслэсэн хүслийг хариулж чадна гэдэг гайхмаар доромжлогдсон газар тариалангийнхан бага зүдэрч баяжихыг хүснэ. Манай бүх хүслийг шидэт үгээр гүйцэлдүүлэх юмуу шатсан чийдэнг эргүүлэх хөшүүрэг мэт үл гүйцэлдэх домгоор тариачны сэтгэл зүйн байгууламж бялхмал юм. Америк техник эдгээр домгийг амьдралд нэвтрүүлж байна. (радикализмын үндсийн тухай мэтгэлцээнийг энэхүү асуудлаар хийвэл сонирхолтой 15, р.504 ff.: 1; 12)

Америкийн мөрөөдөл нь хотод хамгийн сайхан цэнгүүн болж, гайхалтай амжилтад хүрнэ. Бид бүгдээрээ л тиймэрхүү хөөрхөн жижиг юмсыг хүснэ. Тэдгээрийн заримыг Японд юмуу Итали хийсэн ч бай, бид бас амьдралын арга барилаар чимэглээд Америкийн олон нийтэд анх удаа хүртээмжтэй болгоно. Энэ утгаар «Бид цөмөөрөө одоо Америкчууд».

1989 оны дараа Америкийн мөрөөдлийн шинж чанар мэдэгдэм өөрчлөгдсөн. 75 жил АНУ хоёр дайсантай тэмцэл хийсэн. Нэг нь нийгмийн сайн сайхныг ард түмэндээ төлөхийг санал болгосон социализм байв. Хэрвээ энэ загвар байгаагүйсэн бол АНУ-ын засгийн газар шинэ бодлогын дараахан цагт нь сайн сайхны хөтөлбөрийг дэвшүүлчих байсансан.

Нөгөө дайсан нь дэлхийн хоёр дайнд хамтдаа үйл ажиллагаа явуулсан Европын эзэнт гүрнүүд байв. Аль 1982 оны VI сард Рональд Рейган «эзэнт гүрний муу муухайн» тухай үг хэлж, тэр бүх газрын хүмүүс эрх чөлөө олгохын тулд энхтайвны төлөө хөдөлж, загалмайтны аянд мордохыг уриалж байв. 1989 онд хоёр дайснаа ганцхан далайлгаар буулгав. Хятад улс төрийн дайралтын бай болов, гэхдээ түүний зах зээлийн боломж, түргэн хурдацтай эдийн засаг нь тийм бодлого явуулах нь ухаалаг бус болно. Америкийн мөрөөдлийн татах чадвар алдагдалд оров. Тэр нь чөлөөлөх бодлого, өөрчлөх амт шүлгээ алдлаа. Тэр үед Америк хувь хүн, гэр бүлд эрсдэлийн хүндийг үүрүүлэв. Худалдаанд сайн бараа байгаад түүнийг нь худалдан авдаг тэр л цагт шүү дээ. Хэрэв чи үүнийг хүсч байсан ч чамд ямар ч боломж олгохгүйгээр бараа, үйлчилгээний зараар чамайг бөмбөгдөөд байвал шүүмжлэх нь тун амархан шүү дээ.

Бүгдэд, баячууд, ядуучуудад санал болгосон Америкийн зар сурталчилгаа гэдэг нь тэдэнд өөрт нь тус болохгүй байгаагаас хичнээн хүн Америкийг үзэн ядах болсон юм бэ? Энэ хэтийн дипломатч «Янкууд гэртээ харьцгаа, гэхдээ намайг аваад яваарай» гэсэн үгийг дотроо хичнээн хүн хүлээн зөвшөөрч байгаа юм бэ?

Америкийн амжилт ацан шалаа шиг үр дагавартай юм. Технологийн шинэчлэл хийх тэмүүлэл, мэргэжил болох менежментийн хөгжил, Америкийн бизнесийн ялангуяа зах зээлийн өршөөлгүй өрсөлдөөнд хандах хандцыг аваад үзэхдээ: Эдгээр аргыг эхлээд Европ дараа Ази, бүх дэлхийгээр эзэмшсэн. Японы гайхамшиг гэж нэрлэгддэг тэр зүйлд Японы эзэн хааны шагналтан, Америкийн менежментийн онолчид болох У.Эдвардс, Деминг, Джозесер Дюран нарын олон бүтээл шингэсэн юм. (16). 1970-1980 оны үед Америкын ажилчид, эздүүд Япончуудын өрсөлдөөнөөс аж үйлдвэрт ямар их хохирол, хүлээж байгааг мэдэргээсэн юм. Зорилго чиглэлтэй гадаадын үйлдвэрлэгчид Америкийн хандлагуудыг өөрсдөөс нь ч илүү үр дүнтэй ашиглаж байв. 1990-ээд оны уналтын үр дүнд Ази сандралд орсон ч энэ нь мөнх сунжрахгүй. 1930-аад оны хямралын дараах Америкийн эдийн засаг шиг Японы эдийн засаг сэргэнэ, тэгэхдээ урьдынхаасаа улам бат бэх, эрч хүчтэй болно.

Нэгдсэн улс дэлхийн эдийн засгийг америкчлах тутам янз бүрийн салбарт өөртөө өрсөлдөгчдийг бий болгож байна. Жишээлбэл тэд үндэстэн дамнасан корпорациуудын СУДК пионер, гэвч өдгөө хошуучлалаа алдчихжээ. 1995 онд 100 үндэстэн дамнасан корпорациуудын борлуулалтын 30,9 хувийг америкийн ДК эзэлж байсан бол Японы УДК-нх 35,3%, харин үлдэх хэсгийн ихэнх Европынхных болно. (17.р. 35)

Одоохондоо АНУ цэргийн технологийн хүрээнд өөрийгөө бэхжүүлэхийн тулд бүхнийг хийж, ихээхэн давуу байдалтай байна. Давуу талын заримыг хүлээн зөвшөөрөхгүй үед АНУ эдийн засгийн дэмжлэг үзүүлэх замаар л нөлөөлөх гэж үзэцгээдэг. Тусламж нь эргээд шинэ өрсөлдөгчид бий болгодог тэд айдаг гэж үү? Цэргийн чадавхи, ур чадвар, туршлагадаа дулдуйдаад өөрсдийн хүсэл зоригийг тулган, тэд давуу байдлаа хадгалсаар байх бодолгүй юм гэж үү?

Хэрэв дурдсан бодомжуудад үнэний хувь байдаг бол олон засгийн газар, том хотуудын хэрэгцээг гойд анхаарахгүйгээр дэлхийг удирдах боломжгүй гэж үздэг тэднийг хэрэгцээ, ашиг сонирхлыг дутуу тооцох аюул нүүрлэж байна. Үүнтэй уялдуулан Өмнөдийн хотуудын хүн амын орчинд өсөн нэмэгдсээр байгаа хүчдэлийг зайлшгүй задлан шинжлүүштэй.

### **Даяаршсан өмнөдийн хотын ядуурлын асуудлууд**

Баян хойд даяаршсан хотуудын ядууралтай дөнгөж танилцаж байхад түүний улс төрийн хүч өссөөр байна. Эдгээр орнуудад хоол хүнс, ажил, газар, эрүүл мэнд, боловсрол, хүндэтгэл зэргийн ядуурлын хэрэгцээг хангах нь улс төрийн өдөр тутмын асуудал болж байна.

Сьерра-Леонд ядуурал ямархуу байр эзэлдэг нь үүний жишээ юм. Үргэлж тэр нь нийгмийн болон улс төрийн урсгал байдлын өндөр түвшинтэй хавсарч байна. Гэвч ядуурлыг хөгжингүй орнуудын жирийн иргэд материаллаг бараа, үйлчилгээ байдаггүй шиг ойлгож болох л доо. Ядуурлын хоёр хэлбэр давхцана, гэхдээ бүгдээрээ биш. Хойд Америк, Европ, Австрали, Шинэ Зеланд, Японд ундны цэвэр ус, дунд боловсрол, хүүхдүүд нь эрүүл саруул бол бусад байхгүй ч гэсэн чамаас илүүгүй гэж хэлж болно. Сьерра-Леонд (Бангладеш, Йемен буюу Суданд) амьдрахын төлөө бэдэрч яваа залуухан эмэгтэй дэлхийн стандартаар хамгийн ядуу байж болно, гэвч үүнтэй холбогдуулан эндхийн буюу энд бодох цаг ч,эрч хүч ч байхгүй. Олонх тохиолдолд байгалийн гамшиг, дайн, мулгуу удирдлага, авилгалын хамсал нь юуг ойлгох, ямар байхыг бүр ч хүндрүүлнэ. Сайн материаллаг байдалд байгаа хүн туйлын тоон үзүүлэлтээр ядуу байх нь цөөвтөр. Гэвч нөхцөл байдлыг ямар нэгэн байдлаар өөрчлөх боломж илүүтэй байна, эсэргүүцэл ба атаархлын төлөө эрч хүч, цаг зав илүүтэй байна, чи юмгүй ч илүүтэй мэдэх эсэхээр нь багавтар ядуу л гэсэн хэрэг юм.

Улс төрийн дарамт нь хотод амьдрал илүү гэсэн найдлага ядуу айлын хүүхдүүдэд төрүүлж, тэр хэмжээгээр уруудалтыг нэмэгдүүлдэг. Хотын амьдрал нь олон хүнийг төвлөрүүлж, өөрийнхөө байр суургийг бусдынхтай харьцуулах, зохион байгуулахад ихээхэн тус дэм болдог. (18,19)

Жишээлэхэд 1975 онд Хятадад хүн амынх нь 17-хон хувь нь хотын оршин суугчид байсан бол 2075 онд энэ тоо 49,5 нэгжид хүрч, харьцаа нь тавны нэгээс хоёрны нэг болж өөрчлөгдөнө. Индонезод хотын ба хөдөөний оршин суугчдын зөрөөний багасалт мөн хугацаанд ойролцоогоор 19,4-өөс 55,0 хувь болно. (20)

Дэлхийн хамгийн олон хүн амтай 50 хотыг авч үзэхэд (энэ сэдвийг 21 авч үзсэн) том хотуудаас арваас гурав нь, тавиас ес нь умардад, үлдсэн нь өмнөдөд байршиж байна. Тэр бум хүн амтай Энэтхэгт зургаа, 1.3 тэр бум шахуу хүн амтай Хятадад 12 нь байна.

Иймэрхүү нөхцөл байдал нь хотын хүн амын хэрэгцээг хангах зорилгоор засгийн газар аж ахуйн хүчтэй дарамтыг хүлээх болно. Энэхүү хүлээлтийг засгийн газар хэрхэн цайруулж болох вэ? Өдөр дутам хүмүүсийн сонсож буй Америкийн мөрөөдөлтэй ямар нэгэн юмыг тэд санал болгож чадах уу? Хэрвээ нийгэмд эмх замбараагүй байдал үүсвэл засгийн газарт итгэх итгэлийг бусниулах нь тов тодорхой. Энэ нь хүмүүсийн хэрэгцээг хангах хөгжлийн үйл явцыг чөдөрлөнө, харин засгийн газар бахархлаа хадгална.

Хятадад нийгмийн сүйрэл (хаос) гүн гүнзгий нүүрлэх нь сахилга батыг дэмжихэд туслана. Гэвч орчин үеийн сэргэн мандлын өөрийнхөө загвараар урагшлахад тэдэнд дэлхийн эдийн засаг тусалж чадах эсэхэд эргэлзэх цаг үе Хятад, Энэтхэгийн эрх баригчдад ирэхгүй гэж үү? Алан хядлагын эсрэг дайн хяналтаас мултарч, дэлхийн эдийн засаг ганхахгүй юм гэж үү? Өөрийн ард түмнүүдээсээ нүүр буруулах уу, эсвэл олон худалдааны байгууллага, олон улсын Валютын сан, Дэлхийн банкны даяаршлын боловч өөрийн ард түмний хүн амын санал бодлыг тооцон үзэх цаг ирнэ гэдгийг би онцлон тэмдэглэж байна. Тэр үед засгийн газрууд доромжлол авчирдаг хөзрийг сөхөхгүй гэж үү? Тэд өөрсдийн ард түмэндээ бидний ядуу зүдүү амьдарч буйн буруутан барууны орнууд гэж хэлэхгүй юм гэж үү. Тэдний эсрэг олон улсын хуйвалдааны тухай тэд ярилцахгүй юм гэж үү? Баруун капиталист алан хядлагын эсрэг өөрсдийн дайныг дэгдээхгүй гэж үү.

#### **Социологи, нийгмийн ухаан, мэдлэгийн мэргэжилтнүүдийн хувь нэмрийн чадавхи**

Доромжлолын мөчлөгүүд, доромжлолын асуудлуудыг өдөр тутмынх болголтгүй хойшлуулах нь амин чухал юм. Энд шийдвэрлэх үүргийг бүх орон, тивийн нийгмийн ухааны судлаачид тэдний хамтын ажиллагаа гүйцэтгэнэ. «Хүчтэй байхад шударга даяаршлын бодлого бий болгох нь сэтгэл уярам үзэл санаа, ялангуяа үндэсний хил хязгаараасаа гаднах нөхдөөсөө бид улам бүр хамаарах болсон үед боломжтой. Гэвч дэлхийн хүчтэй засаглалын үзэл санаа нь хүчирхэг хоёр бүлгийн эсэргүүцэлгүй тулгарна. Тэр нь бас үндэсний улсуудын тусгаар тогтнолтой хүйн холбоотой үнэ хүнд бүхий цэргийнхэнд таалагдахгүй. Тухайн ямар ч цаг үед үндэсний улсуудын татвар ногдуулалт, хууль тогтоомжоос туйлын эрх чөлөөтэй явдаг үндэстэн дамнасан корпорацынханд мөн таалагдахгүй. Тэд даяаршлын түвшинд зохицуулалтын шинэ сүлжээ бий болгон эсэргүүцнэ. Цэргийнхэн болон бизнесийнхэн сонирхлын хүрээгээрээ ихээхэн элгэмсүү болохоор сэтгэл зовниж яваа улс төрчдөд хөдөлмөрлөх завдал өгөхгүй гэсэн үг яриа энэхүү үзэл санааны эсрэг гарах боломжтой.

Миний хариулт бол иймэрхүү: генералууд, бизнесменүүд, улс төрчид бага гарынхан бишээ, харин бидний олонхи нь илүү бичиг үсэгтэй, мэдээлэлтэй, туршлагатай бөгөөд шийдэмгий. Тэд бас иргэд, ихэнх нь үр ач нартай гэдэгт найдаж байна. Өөрөөр хэлбэл, тэд эрх мэдэл, нэр хүндээ хамгаалаад зогсохгүй тогтвортой бөгөөд аюулгүй ирээдүйг бүтээн байгуулах нь тэр өөрсдөө хүртэл оролцдог хэн бүхэнд үнэ цэнэтэй.

Нийгмийн ухааныхан («мэдлэгийн мэргэжилтнүүд» нь) засгийн дээдэстэй нягт холбоотой. Бид их сургуулиуд, эрдэм шинжилгээ-судалгааны хүрээлэнгүүдээр дамжуулан тэдэнд шинэ сэргэг үзэл санаа, мэдээлэл, мэргэшсэн ажилтнууд өгнө. Хэрэв сурсныгаа ашиглаж чадах юм бол бид илүү хүчтэй нөлөөлж чадна. Дунд ба урт хугацааны цувааг тооцсон орчин цагийн сонирхлыг хэрэгжүүлэхийн тулд бид засаглалын дээдсүүдтэй халз ярилцаж болно. Хэлэлцэх асуудал нь олон улсын ба дотоодын бодлого дахь доромжлолын давамгайлал, засаглал биежил болох даяаршиж болзошгүй үйл явцаас эхлэх учиртай.

Тийм төрлийн үйл ажиллагааг тодорхой үр дагаварт хүргэх бүхий л хувилбарууд бий. Олон туйлт тогтворгүй байдал, доромжлолын өөрчлөлтийг сайтар ойлгох зайлшгүй байдал, ялангуяа олон орны сэтгэгч хүмүүст энэ үзэл санааг хүргэвэл эрх мэдэл бүхий дээдэс эргэцүүлэл бодрол болгон хүлээн авах боломжтой. Нэн ялангуяа, аюул занал «манай хаалгыг цохиж байгаа» үед бид үйлдлэгийн төлөвлөгөөг сонгууштай. Сэхээрэлгүй итгэл үнэмшил бүхий ажил хийхээс өөр сайхан юм одоохондоо алга. Үүнийг эртхэн хийвэл тогтворгүй байдал, мөргөлдөөнийг зайлуулж, улс төрчид, генералуудыг өөрсдийнхөө амьдралын төлөө айдаг болгоно. Үүнд хүрэхгүй юм бол дунд ба хэтийн сонирхлын турай ярих нь хэтэрхий оролцоо. Бид даяаршлын дуудлагын өмнө байна.